



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 11 сарын 14 өдөр

Дугаар А/Э/15

Улаанбаатар хот

Илүү цагаар ажиллуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, 57.2.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1, 91.2 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”, Хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.4.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хангах, санхүү, төсвийн жилийн эцсийн тооллого тооцоо хийх, бодлогын бичиг баримт боловсруулах, архив үүсгэх ажлын зайлшгүй шаардлагаар ажилтан албан хаагчдыг илүү цагаар ажиллуулсугай.

2. Илүү цагаар ажиллах албан хаагчдын ажилласан цагийн мэдээллийг цахим төхөөрөмжөөс татаж баталгаажуулахыг Агентлаг, хяналтын лабораторийн хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэнд үүрэг болгосугай.

3. Илүү цагаар ажилласан ажилтан, албан хаагчдын нэмэгдэл хөлсийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцож олгохыг Санхүү, төсвийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (А.Болор-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэнд даалгасугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА

1422

01215